



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatkhural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2022.10.26 № 43

Ажлын хэсгийн дүгнэлтийг  
тодруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газрын урилгаар НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг 2022 оны 10 дугаар сарын 3-14-ний өдрүүдэд албан ёсны айлчлал хийжээ. Ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлтэд “шүүхийн шийдвэргүйгээр цагдан хорих явдал онцгой тохиолдол гэхээсээ илүү жирийн үзэгдэл хэвээр байгаа, мөн иргэдийг цагдаагийн байгууллагад хуульч байлцуулахгүйгээр байцаалт авдаг байдал хэвшмэл байгаа”, “эрүүгийн мөрдөн байцаагч, прокурорууд асар их, хяналтгүй эрх мэдэл эдэлж байхад талуудын эрх тэгш байдлыг үл тоомсорлон шүүгдэгчдэд зохих хууль эрх зүйн журмын бүхий л баталгааг хангаж өгөхгүй байгаа нь санаа зовоож байна”, “хүний эрхийг хамгаалагчдын хууль ёсны ажилд саад учруулах, ялангуяа тэдний стратегийн хөгжлийн төслүүдийг эсэргүүцэж, тайван замаар үзэл бодлоо илэрхийлэх, цуглаан, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлахад ашиглагдаж болзошгүйд анхаарал хандуулж байна”, “2020 онд баривчлах ажиллагааны 99.3 хувь, 2021 онд 98.3 хувь шүүхийн шийдвэргүйгээр хийгдсэн”, “мөрдөн байцаагч, прокурор нарыг хянан шийдвэрлэсэн хэргийнх нь тоогоор өрсөлдүүлж, сар бүрийн эцэст “ялагч”-ийг зарлаж, цалингийн болон бусад урамшуулал өгдөг практик тогтсон байна”, “КОВИД-19-ийн тархалт зэрэг нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед авч хэрэгжүүлж буй яаралтай арга хэмжээг үзэл бодлоо илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө зэрэг үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлахад ашиглах ёсгүйг онцолж байна” зэргээр олон асуудлуудыг дурджээ. Энэхүү үнэлгээ бодитой эсэхэд ямар үнэлэлт, дүгнэлт хийж байна вэ?

2. Засгийн газраас аливаа хууль, тогтоомжид хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, дордуулахгүй байх талаар ямар хууль, эрх зүйн шинэчлэлийг ойрын хугацаанд хийх талаарх мэдээлэл, судалгааг ирүүлэх.

Дээрх асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд Хууль зүйн байнгын хороонд ирүүлж, мэдээлэл хийнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



С.ОДОНТУЯА

2022000058